

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 04 дүгээр сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2024 оны 1 дүгээр улирал)

7.8 хувь

Валютын нөөц

(2024 оны 4 дүгээр сар)

4,986 сая \$

Инфляц

(2024 оны 4 дүгээр сар)

6.4 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны 4 дүгээр сар)

2.1 их наяд ₮

Экспорт

(2024 оны 4 дүгээр сар)

4,937 сая \$

Импорт

(2024 оны 4 дүгээр сар)

3,426 сая \$

ГШХО

(2023 он)

3.1 тэрбум \$

Зээлийн хүү

(2023 оны 4 дүгээр сар)

17.2 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 1 дүгээр улирал)

1.3 сая

*1 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 60 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)

16.4 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2023 оны эцэс)

96.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)


14.1 хувь



Эдийн засаг 2024 оны эхний улиралд 7.8 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарын үйлдвэрлэл эерэг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Өмнөх оны өндөр суурийн нөлөөгөөр уул уурхайн салбарын оролцоо багасаж, үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Тайлбар: 2024.3 сарын туршилт тооцоо

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(2024 оны 3 дугаар сар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2024 оны эхний улиралд **7.8 хувиар өслөө.**

- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 13.1 хувиар тэлж өсөлтийн 1.9 хувийг, ХАА-н салбар 31.4 хувиар буурч өсөлтийг -1.3 хувиар хязгаарлалаа.

- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 8.5 хувиар өсөж өсөлтийн 0.9 нэгж хувийг;

- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 7.7 хувиар өсөж өсөлтийн 4.1 хувийг ;

- Бүтээгдэхүүний цэвэр татвар 13.1 хувиар өсөж өсөлтийн 2.1 хувийг бүрдүүлсэн байна.

- Үйлчилгээний салбар болон цэвэр татварын орлого нэмэгдсэнээр өсөлтийн дийлэнхийг бүрдүүлж байна. Мөн боловсруулах, барилгын салбарын үйлдвэрлэл өсөлттэй байв.

- Харин том малын зүй бус хорогдол нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар агшив.

- Уул уурхайн салбар 2024 оны эхний улиралд 13.1 хувиар тэллээ.

- Газрын тос, молибдений баяжмал, алтны олборлолтоос бусад уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөллөө.

- ХАА-н салбар 2024 оны эхний 3 сард 31.4 хувиар агшлаа.

- Том малын зүй бус хорогдол 2024 оны 1 дүгээр улиралд 6.3 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдлээ. Энэ нь оны эхний нийт малын 9.8 хувийг эзэлснээр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурч байна.




Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 4 сарын байдлаар 14.3 хувиар өсөөд байна. Нүүрс, төмрийн хүдрийн олборлолт уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг, цагаан архи, ус ундаа, шохойн үйлдвэрлэл боловсруулах үйлдвэрлэлийг дэмжсэн хэвээр байна.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(гэрбум төгрөг)

■ IV.2023 ■ IV.2024



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны эхний 4 сарын байдлаар 9.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд буюу 14.3 хувиар өслөө.
- Нүүрс, төмрийн хүдэр, цайр, мөнгөний баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 15.1 хувиар нэмэгдээд байна.
- Цагаан архи, ус ундаа, самнасан ноолуур, шохой, металл бэлдэц зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбарын үйлдвэрлэл 12.9 хувиар өслөө.

БОДИТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(өсөлтийн хувь)

Бодит үйлдвэрлэлийн өсөлт (салбаруудын өрөлцөө, нэгж хувиар) **10.9** хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, тооцоолол

- Аж үйлдвэрийн салбарын бодит үйлдвэрлэл 2024 оны эхний 4 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өсөөд байна. Үүнд:
- Уул уурхайн салбарын үйлдвэрлэл өсөлтийн 9.5 нэгж хувийг бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өслөө,
- Боловсруулах, цахилгаан, усан хангамжийн салбаруудын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 4.2 хувь, 2.1 хувь, 4.7 хувиар тус тус өссөн байна.

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

(голлох бүтээгдэхүүнээр)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нүүрс олборлолт 2024 оны эхний улиралд 30 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 25 хувиар нэмэгдээд байна.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс 92 хувиар нэмэгдээд байна.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй ойролцоо түвшинд байгаа бол алт олборлолт 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Харин газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс буурсан хэвээр байна.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)

— 2022 — 2023 — 2024



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буурч, цар тахлын өмнөх үеэс 47.4 хувиар өслөө. Үнийн индексийг бүрэлдэхүүнээр харвал:

Үнэ өссөн:

- Хүнсний бүтээгдэхүүн 13.6 хувиар,
- Ундаа, согтууруулах ундаа 11.4 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 8.2 хувиар тус тус өссөн бол

Үнэ буурсан:


- Уул уурхай, олборлолтын үйлдвэрлэл 6.7 хувиар,
- Арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийнх 0.4 хувиар тус тус буураа.



Дотоод эрэлт идэвхжиж, эдийн засгийн өсөлт эрчимжив.

ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эрэлтээс тооцсон ДНБ 2024 оны эхний улиралд 7.8 хувиар өслөө.
- Өсөлтөд эцсийн хэрэглээ 23.4 нэгж хувийн, хөрөнгийн хуримтлал 3.8 нэгж хувийн тус тус зэрэг нөлөө, цэвэр экспорт 19.4 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв.

- Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбоотойгоор төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 47.1 хувиар өсөж, нийт эрэлтийг дэмжиж байна.
- Өрхийн бодит орлого 19.8 хувиар сайжирсан нь нийт өрхийн хэрэглээг дэмжиж, өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар тэлэв.


- Үндсэн хөрөнгийн хуримтлал 5.4 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 6.3 сая толгойд хүрсэн нь эдийн засагдах үндсэн хөрөнгийн хуримтлал буурахад голлон нөлөөллөө.

- Үйлчилгээний экспортын орлого өмнөх оны мөн үеэс багасаж, нүүрс, зэсийн баяжмалын үнийн бууралтаас шалтгаалан бараа, үйлчилгээний экспорт 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурав.
- Бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өсөхөд барааны импорт 24.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 2024 оны эхний 4 сарын байдлаар 1,511 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 37.7 хувиар буурлаа.

ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2024 оны эхний 4 сард 4,937 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3 хувиар буурлаа.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхай бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 60 хувийг бүрдүүлж байна.


- Нүүрсний экспортын орлого 2,988 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурлаа.
- Зэсийн баямжлын экспортын орлого 872 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 292 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 189 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 21 хувиар өслөө.

- 2024 оны эхний 4 сард импорт 3,426 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 28.9 хувиар өссөн байна.
- Нийт импортын 20 хувийг нефть, 18 хувийг тоног төхөөрөмж, 9 хувийг автомашин эзэлж байна.

- Нефтийн бүтээгдэхүүний импорт 670 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 34.8 хувиар өслөө.
- Тоног төхөөрөмжийн импорт 624 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 40.6 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 324 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 74.2 хувиар өслөө.




2024 оны эхний 4 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспорт 2024 оны 4 дүгээр сард 6.8 сая тоннд хүрч, оны мөн үеэс 29 хувиар өслөө. өнгөрсөн
- Гашуунсухайт боомтоор 3.3 сая тонн, Шивээхүрэн боомтоор 2.3 сая тонн, Ханги боомтоор 0.6 сая тонн, бусад боомтуудаар 0.4 сая тонн нүүрс тус тус экспортолсон байна.



- Зэсийн баяжмалын экспорт 2024 оны 4 дүгээр сард 132 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 10 хувиар өслөө.
- Гашуунсухайт боомтоор 86 мянган тонн, Замын-Үүд боомтоор 46 мянган тонн зэсийн баяжмал тус тус экспортолсон байна.



- Төмрийн хүдрийн экспорт 2024 оны 4 дүгээр сард 564 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 28 хувиар өслөө.
- Замын-Үүд боомтоор 539 мянган тонн, Бургастай боомтоор 14 мянган тонн, бусад боомтуудаар 11 мянган тонн төмрийн хүдэр тус тус экспортолсон байна.




- Газрын тосны экспорт 2024 оны 4 дүгээр сард 358 мянган баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 14 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 324 мянган баррель, Замын-Үүд боомтоор 34 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.




2024 оны эхний 4 сарын байдлаар сарын ноос, ноолуураас бусад голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ (тонн)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

БОЛОВСРУУЛСАН АРЬС ШИР (мянган дм квадрат)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООЛУУР (тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС (тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2024 оны эхний 4 сард 15,546 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 51 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багасаж 5,555 мянган тоннд хүрлээ.

- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 4 сард 29,133 мянган дм квадратад хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 36 хувиар буурлаа.

- Ноолуурын экспорт 2024 оны эхний 4 сард 288 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 21 хувиар өслөө.

- Ноосны экспорт 2024 оны эхний 4 сард 53 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 59 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА




[PowerBi report](#)

Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоос

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)




Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний 4 сарын дундаж үнэ 293 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 11 хувиар буурсан байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 250 ам.доллар, 2025 онд 215 ам.долларт хүрэхээр байна.

ЗЭС

(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)




Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны эхний 4 сарын дундаж 8,697 ам.доллар болж, өмнөх оны мөн 2 хувиар буурсан байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 8,800 ам.доллар, 2025 онд 9,000 ам.долларт хүрэхээр байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)




Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны эхний 4 сарын дундаж үнэ 120 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 2 хувиар буурсан байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн баяжмалын дундаж үнэ 2024 онд 120 ам.доллар, 2025 онд 100 ам.долларт хүрэхээр байна.

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг

- Бrent газрын тосны 2024 оны эхний 4 сарын дундаж үнэ 82 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 7 хувиар өслөө.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 85 ам.доллар, 2025 оны дундаж үнэ 80 ам.долларт хүрэхээр байна.




МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ҮНИЙН ХАНДЛАГА



[PowerBi report](#)


Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоос

НҮҮРС (\$/тонн, Хил үнэ)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯЖМАЛ (\$/тонн, Хил үнэ)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН БАЯЖМАЛ (\$/тонн, Хил үнэ)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС (\$/баррель, Хил үнэ)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Чулуун нүүрсний 2024 оны 4 дүгээр сарын хилийн дундаж үнэ 115 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 26 хувиар буурсан байна.



- Зэсийн баяжмалын хилийн үнэ 2024 оны 4 дүгээр сарын дундажаар 1,772 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн байна.

- Төмрийн хүдрийн 2024 оны 4 дүгээр сарын дундаж үнэ 80 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурсан байна.

- Газрын тосны 2024 оны 4 дүгээр сарын дундаж үнэ 86 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 11 хувиар өссөн байна.



2024 оны эхний 4 сарын байдлаар 2023 оноос хойш УУББ-ээр 9 төрлийн, нийт 24 сая тонн нүүрс болон 1,212 мянган тонн төмрийн хүдэр болон баяжмал, 2.7 мянган тонн зэсийн баяжмалыг арилжаалаад байна.



- 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 2023 оноос хойш нийт 24 сая тонн нүүрс арилжиж, 33 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 2024 онд 9.4 сая тонн нүүрс арилжиж, 1,216 сая ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 3 дугаар сард 1.3 сая тонн нүүрс борлуулсан бол 4 дүгээр сард 4.2 сая тонн нүүрс борлууллаа.

- 4 дүгээр сард нүүрсний дуудах дундаж үнэ 120 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 109 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 4 дүгээр сард хэлцлийн доод үнэ 58 ам.доллар, дээд үнэ 180 ам.долларт хүрэв.

- 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 1.2 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 97 сая ам.доллороор борлууллаа.
- 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 2024 онд 535 мянган тонн төмрийг арилжаалж, 40 сая ам.долларын орлого олжээ.

- Төмрийн хүдэр болон баяжмалын 4 дүгээр сарын дуудах дундаж үнэ 62 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 66 ам.доллар болж буурав.
- Төмрийн төрлөөс хамааран 4 дүгээр сард хэлцлийн доод үнэ 61 ам.доллар, дээд үнэ 73 ам.долларт хүрэв.

4.2 УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА - Компаниар 2024.04 сар



2024 ОНЫ ЭХНИЙ 4 САРЫН НИЙТ АРИЛЖАА



[PowerBi report](#)

Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоо

юанаарх үнийг ам.доллар луу шилжүүлэв.

НИЙТ НҮҮРС		
9,408.0	\$1,215,819	102
мян. тонн	мян. \$	арилжаа

НИЙТ ТӨМӨР		
534.6	\$39,739	82
мян. тонн	мян. \$	арилжаа

НИЙТ ЗЭСИЙН БАЯЖМАЛ		
2.7	\$5,821	1
мян. тонн	мян. \$	арилжаа

НҮҮРС		
"Эрдэнэс Тавантолгой" ХК		
7,865.6	\$986,850	18
мян. тонн	мян. \$	арилжаа
"Энержи Ресурс" ХХК		
1,516.8	\$225,509	82
мян. тонн	мян. \$	арилжаа
"Хангад Эксплорэйшн" ХХК		
25.6	\$3,460	2
мян. тонн	мян. \$	арилжаа

ТӨМРИЙН БАЯЖМАЛ		
"Монголросцветмет" ТӨҮГ		
99.0	\$9,819	18
мян. тонн	мян. \$	арилжаа
"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК		
122.8	\$8,518	19
мян. тонн	мян. \$	арилжаа

ЗЭСИЙН БАЯЖМАЛ		
"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ		
2.7	\$5,821	1
мян. тонн	мян. \$	арилжаа

ТӨМРИЙН ХҮДЭР		
"Монголросцветмет" ТӨҮГ		
227.7	\$16,424	33
мян. тонн	мян. \$	арилжаа
"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК		
85.1	\$4,979	12
мян. тонн	мян. \$	арилжаа



2024 ОНЫ ЭХНИЙ 4 САРЫН НИЙТ АРИЛЖАА




[PowerBi report](#)

Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоо

юанарх үнийг ам.доллар луу шилжүүлэв.


Нүүрс

Жигнэсэн дундаж үнэ (\$)




Төмөр

Жигнэсэн дундаж үнэ (\$)




Зэсийн баяжмал


Жигнэсэн дундаж үнэ (\$)



Биет хэмжээ (мян. тонн)



Биет хэмжээ (мян. тонн)




Биет хэмжээ (мян. тонн)






Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 3 сард ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2024 оны 4 дүгээр сард өмнөх сараас 264 сая ам.доллар буюу 5.0 хувиар буурч, төгрөгийн ам.доллартой харьцах ханш суларлаа.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)




- Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 3 сард 373 сая ам.долларын ашигтай гарч, ашиг өмнөх оны мөн үеэс 294 сая ам.доллараар өслөө.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 116 сая ам.доллараар нэмэгдсэн ч импортын өсөлт 640 сая ам.долларт хүрснээр урсгал дансны ашиг өмнөх оны мөн үеэс буурлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны эхний 3 сард 713 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 395 сая ам.доллараар өссөн байна.

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)




- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 4 дүгээр сарын эцэст 4,986 сая ам.доллар болж, өмнөх сараас 264 сая ам.доллараар буурч, өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллараар буюу 35.1 хувиар өслөө.

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



- 2024 оны 4 дүгээр сард төгрөгийн ам.доллартой харьцах ханш өдөрт дунджаар 0.1 төгрөгөөр суларлаа.
- 2024 оны 4 дүгээр сарын эцэст төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,378 болж, оны эхнээс 32 төгрөгөөр буюу 0.9 хувиар чангарлаа.

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)



- Төв банк 2024 оны 4 дүгээр сард нийт 606 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 584 сая ам.доллар буюу 28 дахин их, 2022 оны мөн үеэс 77 сая ам.доллараар буюу 11 хувиар бага дүн байв.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн



Инфляц 2024 оны 4 дүгээр сард 6.4 хувьд хүрлээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

САРЫН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

СУУРЬ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд 6.4 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.2 нэгж хувь (34.1%)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 4.2 нэгж хувь буюу 65.9 хувийг эзэлж байна.


- 2024 оны 4 дүгээр сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөхөд хүнсний бүлэг 83.7 хувиар нөлөөлжээ.
- Сарын инфляцад мах, махан бүтээгдэхүүн 65%, сүү 5%, талх, гурил, будаа 5%-ийг тус тус бүрдүүлж байна.

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 4 дүгээр сард суурь инфляц 5.6 хувь гарч, нийт инфляцын 3.7 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 8 сар дараалан буурч байна.

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 4 дүгээр сард жилийн инфляцын 23 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өслөө.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар өссөн нь голлон нөлөөллөө.



- Нэгдсэн төсөв 2024 оны 4 дүгээр сард 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 1,034.1 тэрбум төгрөг буюу 94 хувиар өссөн байна.

- Орлого 2024 оны 4 дүгээр сард 10.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.2 их наяд төгрөг буюу 44.5 хувиар нэмэгдсэн байна.
- Дээрх өсөлтөд орлогын албан татвар 1.5 их наяд төгрөг буюу 74.9 хувиар, АМНАТ 82.7 тэрбум төгрөг буюу 5.8 хувиар, НӨАТ 480.4 тэрбум төгрөг буюу 37.3 хувиар тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө.


- Зарлага 2024 оны 4 дүгээр сард 7.8 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2.2 их наяд төгрөг буюу 38.7 хувиар нэмэгдсэн байна.
- 2024 онд төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар, алслагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалин 20-40 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

- Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 29.8 их наяд төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 33.7 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өр (ӨҮЦ)-ийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.




Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн хурд өмнөх сараас 5.4 нэгж хувиар буурлаа. Өмнөх сартай харьцуулахад гадаад валютын харилцах, хадгаламж буурч, төгрөгийн харилцах, хадгаламж нэмэгдсэн байна. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт өмнөх сараас 1.7 нэгж хувиар нэмэгдлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)



ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 4 дүгээр сарын эцэст 38.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.3 хувиар өссөн байна.
- Төгрөгийн харилцах, хадгаламж нийт өсөлтийн 24.5 нэгж хувийг, гадаад валютын харилцах, хадгаламж нийт өсөлтийн 1.5 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- Нийт хадгаламж 23.0 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 21.8 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 18.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 37.6 хувиар, өмнөх сараас 2.8 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.5 хувиар, өмнөх сараас 3.3 хувиар тус тус буурлаа.


- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2024 оны 4 дүгээр сарын эцэст 29.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 6.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурсан байна.

- Банкнуудын зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 4 дүгээр сард 17.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар өслөө.
- Банкнуудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 4 дүгээр сард 11.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар өслөө.



Цар тахлын улмаас буураад байсан хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр өсөж, ажиллагчдын тоо 1.3 саяд хүрлээ.

АЖИЛЧДЫН ТОО, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 182.3 мянгаар нэмэгдэж, 1,293.6 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 150.5 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 1 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 129.2 мянгаар нэмэгдсэн бол эмэгтэй ажилчид өмнөх оны мөн үеэс 53.2 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажиллах хүчний оролцооны түвшин 60.0 хувь болж өссөн ч цар тахлын өмнөх үеэс 0.7 хувиар өндөр байна.
- Ажилгүй иргэдийн тоо 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 7.8 мянган хүнээр буурч, 71 мянгад хүрлээ.
- Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурч, 5.2 хувьд хүрлээ.


АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажилчдын тоо 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.3 саяд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 182 мянган хүнээр нэмэгдлээ.
- Ажилчдын тооны өсөлтөд, үйлчилгээ ба бусад, худалдаа, хөдөө аж ахуй, уул уурхай, барилга, ус, цахилгааны салбарын ажилчид эергээр нөлөөлсөн.
- Харин тээвэр, боловсруулах салбарын ажилчид сөргөөр нөлөөлөө.

ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өсөж, 2,235 мянган төгрөгт хүрлээ.
- Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж, улсын дунджаас 2.3 дахин өндөр байна.




ААН-ийн бодит борлуулалт 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 7.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 32 хувиар өслөө. Борлуулалт өсөлтийн 24.9 нэгж хувийг худалдааны салбар бүрдүүлээ.


ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ААН-ИЙН ӨСӨЛТ (нэгж хувь, бүтцээр)



НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО (мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)



ААН-ИЙН БОДИТ БОРЛУУЛАЛТ (тэрбум, 2015 оны үнээр)



ААН-ИЙН БОДИТ БОРЛУУЛАЛТ (2024 оны 04 дүгээр сар)



- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 4 хувиар буурч 241 мянгад хүрлээ. Үүнд, үйл ажиллагааг түр зогссон ААН-ийн тоо буурсан нөлөөллөө. Харин үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо өсөлтөө хадгалж байна.
- ААН-ийн үйл ажиллагаа илүү идэвхжиж, нийт бүртгэлтэй ААН-д үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн эзлэх хэмжээ сүүлийн 5 жилийн дээд түвшин буюу 41 хувьд хүрлээ /2021-2023 онуудад 37 хувь байсан/.

- Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 хувиар өсөж, 97.8 мянгад хүрчээ.
- Уг өсөлтийн 3.3 нэгж хувийг худалдаа, үйлчилгээний 1-9 ажилтантай жижиг аж ахуйн нэгжүүд бүрдүүлж байна.


- 2024 оны 4 дүгээр сард ААН-ийн бодит борлуулалтын орлого 7.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 32 хувиар өслөө.

- 2024 оны 4 дүгээр сарын байдлаар ААН-ийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 31.6 хувиар өсжээ.
- Боловсруулах болон уул уурхайгаас бусад салбарт ААН-ийн борлуулалт өслөө.
- Тэр дундаа худалдааны салбарын борлуулалт нэмэгдсэн нь борлуулалтын орлогын өсөлтийн 24.9 нэгж хувийг бүрдүүлсэн байна.



Худалдааны салбар ААН-ийн бодит борлуулалтын 57.3 хувийг дангаараа бүрдүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалт 49.2 хувиар өсөв.

ААН-ИЙН БОДИТ БОРЛУУЛАЛТ
(салбараар, тэрбум, 2015 оны үнээр)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

- 2024 оны 4 дүгээр сарын байдлаар худалдааны салбар ААН-ийн бодит борлуулалтын 57.3 хувийг дангаараа бүрдүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалт 49.2 хувиар өсөв.
- Худалдааны салбарын араас цахилгаан (5.2%), санхүү, даатгал (4.9%), төрийн удирдлага, батлан хамгаалах (4.4%) салбарууд борлуулалтад эзлэх хэмжээгээр удаах байранд орж, бодит борлуулалтын өсөлтийн 5.2 нэгж хувийг бүрдүүлсэн байна.


ААН-ИЙН БОДИТ БОРЛУУЛАЛТ
(салбараар, тэрбум, 2015 оны үнээр)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

- 2024 оны 4 дүгээр сарын байдлаар уул уурхайн салбарын бодит борлуулалтын цар тахлын өмнөх түвшинд хүрэхгүй байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 22 хувиар буурсан байна.


ААН-ИЙН НЭРЛЭСЭН БОРЛУУЛАЛТ
(тэрбум)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

- 2024 оны 4 дүгээр сарын байдлаар нэрлэсэн үнээрх аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого 16.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 41 хувиар өсжээ.

ААН-ИЙН ХЭВЛЭСЭН НӨАТ-ЫН БАРИМТЫН ТОО
(сая)




Эх сурвалж: Татварын ерөнхий газар

- ААН-ийн хэвлэсэн НӨАТ-ын баримтын тоо 2024 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеүдээс дээд түвшинд хүрлээ.
- Үүнд, санхүү, даатгалын салбарын хэвлэсэн баримтын тоо огцом нэмэгдсэн нь нөлөөлжээ.




ОХУ-ын Төв банк мөнгөний бодлогын хүүг 16 хувьд барих шийдвэр гаргасан бөгөөд инфляцын дарамт аажмаар буурч байгаа ч өндөр хэвээр байна.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ (хувь)




- Дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны 4 дүгээр улиралд 5.8 хувиар өслөө.
- Засгийн газрын хэрэглээний зардал 2023 оны 4 дүгээр улиралд 6.0 хувиар өссөн байна.
- ОХУ-ын цэргийн армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн зардал тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой эдийн засаг 2022 оны 1 дүгээр улирлаас хойш хамгийн өндөр өсөлт хүрээд байна.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ (хувь, өссөн дүнгээр)




- Экспорт 2024 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсөж, 2022 оны 10 дугаар сараас хойш хамгийн өндөр өсөлтөд хүрлээ.
- Экспортын өсөлтийг газрын тос, байгалийн хийн үнийн өсөлт голчлон дэмжсэн байна.
- Импорт 2024 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар буурсан байна.
- Импортын бууралтад мөнгөний хатуу бодлого гол нөлөөлөл үзүүлсэн байна.

ИНФЛЯЦ (хувь)



- Инфляцын түвшин 2024 оны 4 дүгээр сард нэг жилийн дээд түвшин болох өмнөх сараас 0.1 нэгж хувиар өсөж, 7.8 хувьд хүрлээ.
- Инфляцын түвшин 2023 оны 12 дугаар сараас хойш аажмаар өсөж, Төв банкны зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байна.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 4 дүгээр сард 54.3 болж, өмнөх сарын үзүүлэлтээс 1.4 нэгж хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн хэмжээ, шинэ захиалга, гадаад эрэлт буурсантай холбоотой салбарт 2024 оны 1 сараас хойших хамгийн зөөлөн тэлэлт болов.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт үйлдвэрлэл, уул уурхайу салбарын өсөлт удааширсантай холбоотой өмнөх сараас 4.5 нэгж хувиар буурсан байна.




Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 4 дүгээр сард өмнөх сараас буурлаа. Харин гадаад худалдаа болон аж үйлдвэрлэлийн өсөлтийн хурд эрчимжлээ.




- Өмнөх оны суурь үеийн нөлөө саармагжиж, экспорт 2024 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар өслөө.
- Импортын жилийн өсөлт 2024 оны 4 дүгээр сард 8.4 хувьд хүрч, хүлээлтээс давлаа.



- 2024 оны 4 дүгээр сард аж үйлдвэрийн гарцын өсөлт 6.7 хувь болж, өмнөх сараас 2.2 нэгж хувиар өссөн бол жижиглэн худалдааны өсөлт өмнөх сараас 0.8 нэгж хувиар буурч, 2.3 хувьд хүрлээ.



- Хэрэглээний үнийн индекс сүүлийн 3 сар дараалан өсөж, 2024 оны 4 дүгээр сард өмнөх оноос 0.3 хувиар өслөө.
- Харин үйлдвэрлэгчийн үнийн бууралт сүүлийн 19 сар дараалан үргэлжилж, 2024 оны 4 дүгээр сард өмнөх оноос 2.5 хувиар буурлаа.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 4 дүгээр сард 50.4 болж, өмнөх сараас 0.4 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас мөн өмнөх сараас буурсан ч босго утга 50-аас өндөр хэвээр байна.

Тус индекс нь богино хугацааны идэвхлэлийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ